

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2024/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ингүүмэл жаргалант аудит ХХК Ахлах аудитор: Г. Энхтөр Утас: 80281690	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Цахим хаяг: ij17.audit@gmail.com
---	--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орхон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайшанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.03.15 № 16/289

танай _____-ны № _____-т

БОРХОЙН БАЯН БҮРД
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
З.ЦЭЦЭНТӨГС ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд тусгагдсан 25,699.4 мянган төгрөгийн бараа материал болон 1,679,643.0 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй, эд хариуцагчийн үлдэгдлийг сар бүр баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3 "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтууд, Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал"-ын 6 дугаар зүйлийн 6.3 "Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл", 6.4 "Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3 дугаар зүйлийн 3.5 "Агуулахын бүртгэл" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, иж бүрэн байх, оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант хугацааны санхүүгийн тайлангаар харьяа Татварын байгууллагад 49,595.1 мянган төгрөгийн өглөгтэй байгаа боловч тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө

010903713

хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байгаа боловч эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцээгүй, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд конторын барилгын их засварт 16,643.6 мянган төгрөг зарцуулсан мөн НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болсон 93,323.5 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг орлогод авч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Шилэн дансны цахим мэдээллийн санд 794.2 сая төгрөгийн 95 мэдээллийг байршуулахаас 16.0 сая төгрөгийн 3 мэдээллийг хоцроож, 705.0 сая төгрөгийн 89 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Тус байгууллага 2023 оны 5 дугаар сараас эхлэн Нэмэгдсэн ертгийн албан татварын тухай хуульд заасан шаардлагын дагуу НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,052,616.79	45,101,170.10
Дансны авлага	12,000,000.00	-
Бараа материал	28,090,605.00	25,699,445.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	51,143,221.79	70,800,615.10
Үндсэн хөрөнгө	129,600,880.44	331,493,022.98
Биет бус хөрөнгө	1,348,150,000.00	1,348,150,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,477,750,880.44	1,679,643,022.98
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,528,894,102.23	1,750,443,638.08
Татварын өр	2,130,499.32	46,595,107.78
Урьдчилж орсон орлого	105,203,133.40	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	107,333,632.72	46,595,107.78
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	107,333,632.72	46,595,107.78
Экдийн өмч-хувийн	1,389,469,766.80	1,389,469,766.80
Хуримтлагдсан ашиг	32,090,702.71	314,378,763.50
Тайлангийн үеийн ашиг / алдагдал /	16,726,054.27	282,288,060.79
Өмнөх үеийн ашиг / алдагдал /	15,364,648.44	32,090,702.71
Эздийн өмчийн дүн	1,421,560,469.51	1,703,848,530.30
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,528,894,102.23	1,750,443,638.08

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	278,143,463.42	452,034,618.73
Борлуулалтын өртөг	12,149,500.00	-
Нийт ашиг(алдагдал)	265,993,963.42	452,034,618.73
Бусад орлого	-	251,326,519.29
Ерөнхий ба удирдлагын зардал	247,694,918.70	389,707,737.14
Бусад зардал	1,390,000.00	-
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	16,909,044.72	313,653,400.88
Орлогын татварын зардал	182,990.45	31,365,340.09
Татварын дараах ашиг (алдагдал)	16,726,054.27	282,288,060.79
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	16,726,054.27	282,288,060.79
Орлогын нийт дүн	16,726,054.27	282,288,060.79

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/		
	Өмч	Хуримтлагдсан ашиг	2023 оны 12-р сарын 31
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,389,469,766.80	15,364,648.44	1,404,834,415.24
Залруулсан үлдэгдэл	1,389,469,766.80	15,364,648.44	1,404,834,415.24
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		16,726,054.27	16,726,054.27
2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,389,469,766.80	32,090,702.71	1,421,560,469.51
Залруулсан үлдэгдэл	1,389,469,766.80	32,090,702.71	1,421,560,469.51
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	282,288,060.79	282,288,060.79
2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,389,469,766.80	314,378,763.50	1,703,848,530.30

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	278,143,463.42	487,979,578.40
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	212,031,800.00	446,129,078.40
Бусад мөнгөн орлого	66,111,663.42	41,850,500.00
Мөнгөн зарлагын дүн (-)	261,585,246.48	364,382,744.09
Ажиллагчдад төлсөн	115,557,899.70	173,685,727.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	32,645,287.70	49,939,855.08
Бараа материал худалдан авахад төлсөн	41,955,752.00	22,682,840.00
Ашиглалтын зардалд төлсөн	2,127,017.03	832,500.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,612,622.64	4,084,334.93
Татварын байгууллагад төлсөн	10,375,243.16	37,416,157.14
Даатгалын төлбөрт төлсөн		11,095,160.00
Бусад мөнгөн зарлага	38,311,424.25	64,646,169.94
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	16,558,216.94	123,596,834.31
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн зарлагын дүн (-)	23,879,590.00	89,548,281.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,879,590.00	89,548,281.00
Бусад олгосон зээл болон урьдчилгаа	12,000,000.00	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(23,879,590.00)	(89,548,281.00)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	38,108,263.09	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	38,108,263.09	-
Мөнгөн зарлагын дүн (-)	38,457,513.09	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	38,457,513.09	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(349,250.00)	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(7,670,623.06)	34,048,553.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,723,239.85	11,052,616.79
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,052,616.79	45,101,170.10

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Нийт орлого	278,143.5	29074.5	703,361.1	674,286.6	
Үүнээс:					
Үндсэн үйл ажиллагааны орлого	278,143.5	29,074.5	38,045.9	8,971.4	135
Санхүүжилтын орлого	-	-	413,988.7	413,988.7	-
Хандив тусламжийн орлого			251,326.5	251,326.5	
Нийт зардал	261,234.4	454,141.9	389,707.7	(64,434.2)	86
Үүнээс:				-	
а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	12,149.5	-		-	
б) Ерөнхий ба удирдлагын зардал	249,084.9	454,141.9	389,707.7	(64,434.2)	86
Татварын өмнөх ашиг /алдагдал/	16,909.1	(425,067.4)	313,653.4	738,720.8	
Орлогын татварын зардал	183.0		31,365.3	31,365.3	
Цэвэр ашиг, алдагдал	16,726.1	(425,067.4)	282,288.1	707,355.5	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 359,804.3 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс, 359,804.3 мянган төгрөгийн 6 алдааг залрууллаа.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Борлуулалтын орлогод ноогдох НӨАТ-ыг бүртгээгүй байсан	1	48,798.0					1	48,798.0				
Худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг бүртгээгүй байсан	1	10,945.9					1	10,945.9				
Хандиваар ирсэн хөрөнгийг УОО-оор бүртгэсэн байсан	1	244,947.1					1	244,947.1				
Их засварын ажлыг капиталжуулаагүй.	1	16,643.2					1	16,643.2				
Усны нөөцийн сав /50 тн/-г үндсэн хөрөнгөөр бүртгээгүй	1	6,379.5					1	6,379.5				
Өмнөх оны үр дүнгийн үлдэгдэл	1	32,090.7					1					
Дүн	6	359,804.3					6	359,804.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Татварын байгууллагатай тооцоо хийлээгүй	1	49,595.1			1	49,595.1							
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж биелүүлээгүй	1	-			1	-							
Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй, үлдэгдэл баталгаажуулаагүй	1	-			1	-							
Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй	1	-			1	-							

Санхүү-гийн тайланг А маягтаар тайлагнаагүй	1	-				1	-			
Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэ-лийн тайланг гаргаагүй	1	-				1	-			
Санхүү-гийн тайлангаа Сангийн яамны зөвшөөрөлгүй програм ашиглаж байна.	1	-				1	-			
Тооллогын баримтыг нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн баримт байхгүй байна	1	-				1	-			
Дүн	8	49,595.1			4	49,595.1	4	-		

5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАРСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

Шилэн дансанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, хугацаанд нь мэдээлээгүй болон бусад холбогдох хууль, дүрэм журам зөрчсөн 704,985.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд 3 мэдээлэл хоцроож, 89 мэдээлэл байршуулаагүй	1	704,985.5			1	704,985.5		
Дүн	1	704,985.5			1	704,985.5		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг хүргүүлээгүй	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Нийт дүн	2	704,985.5			2	704,985.5		